



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/450

Улаанбаатар хот

Нэгжийн индексийг шинэчлэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, "Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах тухай" Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/227 дугаар тушаал, байгууллагын даргын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн "Орон нутаг дахь газрын бүтэц орон тоог батлах тухай" Б/347 дугаар тушаал, Архивын ерөнхий газрын 2009 оны 68 дугаар тушаалаар баталсан "Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар"-ын 2 дугаар зүйлийн 2.3.7-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаадын иргэн, харьяатын газрын төвийн нэгжийн индексийг 1 дүгээр, Орон нутаг дахь газар нэгжийн индексийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Удирдлага, зохион байгуулалтын баримт бичигт хавсралтаар батлагдсан индексийг 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг холбогдох нэгжийн дарга нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /Д.Давааням/-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Гадаадын иргэн, харьяатын газрын даргын "Нэгжийн индекс тогтоох тухай" 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/54 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Д.МӨРӨН

000001846

Гадаадын иргэн, харьяатын газрын
даргын 2018 оны 12 дугаар сарын
28-ны өдрийн А/1450 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт



ТӨВИЙН НЭГЖИЙН ИНДЕКС

№	Зохион байгуулалтын нэгж	Индекс
1	Дарга	01
2	Дэд дарга	02
3	Захиргаа, удирдлагын газар	03
4	Виз, зөвшөөрөл, харьяатын газар	04
5	Хяналт шалгалтын газар	05
6	Санхүү, хангалт, үйлчилгээний газар	06
7	Эрх зүй, гадаад харилцааны хэлтэс	07
8	Мэдээллийн технологийн хэлтэс	08
9	Хяналт, шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэс	09

---oOo---

Гадаадын иргэн, харьяатын газрын
даргын 2018 оны 12 дугаар сарын
28-ны өдрийн 4/14/18 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

ОРОН НУТАГ ДАХЬ ГАЗАР ХЭЛТЭС

№	Зохион байгуулалтын нэгж	Индекс
1	Агаарын замын боомт хариуцсан газар	10
2	Дорноговь аймаг дахь газар	11
3	Зүүн бүс дэх газар	12
4	Өмнөд бүс дэх газар	13
5	Хойд бүс дэх газар	14
6	Баруун бүс дэх газар	15
7	Баян-Өлгий аймаг дахь хэлтэс	16